

<https://doi.org/10.65816/jsds.2025.04.017>

Цэргийн сургалтын тогтолцоог төгөлдөржүүлэх бодомж

Ц.Дашзэвэг

*Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
Батлан хамгаалах судлалын төв*

ABSTRACT

This article aims to share the researcher's views and ideas on improving the military training system. The planning and organization of military training and preparation in the units and branches of the Armed Forces vary depending on composition of servicemen. While the objectives, principles, and methodologies of military training for units with professional personnel are consistent, those of units staffed by conscripts differ in their goals, principles, and training approaches.

Keywords: *military training, professional personnel, combat training, sub-system of military training, military unit, organization, officer's training, contract military service, conscript military service.*

Монгол Улсад “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг цэрэг татлагаар болон гэрээгээр сайн дурын үндсэн дээр нөхөн хангах” зарчим мөрдөгдөж байна. Зэвсэгт хүчний нийт бүрэлдэхүүний 40 гаруй хувийг цэргийн мэргэжлийн үнэмлэх, дипломтой ахлагч бүрдүүлэх боллоо. Энэ бол цэргийн том шинэчлэл. Манай зэвсэгт хүчинд иргэн гэрээгээр цэргийн алба хаалгах боллоо. Энэ бол цэргийн шинэчлэлийн бодлогын хүрээнд нийгдэж байгаа бас нэгэн өөрчлөлт. Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг бүрдүүлэх хүрээнд цэргийн ангиудын бүтцэд байнгын бүрэлдэхүүнтэй байлдааны салбаруудыг байгуулж, цэргийн гэрээт түрүүч, байлдагчаар нөхөн хангах бодлого баримталж байгаа хэдий ч харамсалтай нь тэдгээр салбарын тоо төдийлөн нэмэгдэхгүй, бие бүрэлдэхүүний нөхөн хангалт дутагдалтай, ахуй хангалтын чиглэлээр авах арга хэмжээ нэгдсэн бодлогогүй, энэ хэрээр тэдгээр цэргийн салбаруудын цэргийн бэлтгэл, жигдрэлт шаардлага хангахгүй хэвээр байна. Гэрээт цэргийн албаны харилцаа эдүгээ төдийлөн төлөвшихгүй байгаагийн учир шалтгааныг миний өнгөц хийсэн дүгнэлтэд тулгуурлан дурдваас нэгд, цэргийн гэрээт албанд иргэдийг элсүүлэх уяан хатан удирдагдахуйц тогтолцоо эдүгээ хүртэл бүрдээгүй, хоёрт, байнгын бүрэлдэхүүнтэй цэргийн анги, салбаруудын үүрэг, ач холбогдлыг цэргийн захиргааны удирдлагын байгууллагууд дутуу үнэлсээр байгаа бөгөөд үүний харгайгаар шат шатны захирагч, штабын дарга нар тэдгээрийн бэлтгэл, жигдрэлтэд анхаарал муу хандуулсаар, гуравт, цэргийн гэрээт алба хаагчдын албаа хаах нөхцөлийг дээшлүүлэхэд чиглэсэн удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээ дутагдалтай байгаад оршино гэж үзэх үндэстэй байгаа юм.

“Дайнд хэрэгтэй бүхэнд цэргийг сурга!”, “Сургагдаагүй цэргийг байлдаанд оруулах нь гэмт хэрэг” гэсэн цэргийн алдарт жанжингуудын сургаал өнөөдөр ч зайлшгүй авч үзэх хүчтэй сургамж хэвээр байна. Цэргийн салбар, ангийн байлдааны бэлтгэл сургалт нь манай Зэвсэгт хүчний тайван цагийн үндсэн хөдөлмөр мөн. Зэвсэгт хүчин мэргэжлийн цэрэгт суурилна гэдэг бол түүний цэргийн нийт нэгтгэл, ангиудын дийлэнх олонх нь цэргийн мэргэжил бүхий байнгын бүрэлдэхүүнтэй байхыг хэлж байгаа юм.

Манай Зэвсэгт хүчний Агаарын цэргийн болоод Тусгай хүчний төрлийн цэргийн анги, салбарууд үндсэндээ мэргэжлийн байнгын бүрэлдэхүүнтэй болоод байна. Мөн Хуурай замын цэргийн командлалын цэргийн зарим ангиуд ч мэргэжлийн байнгын бүрэлдэхүүнтэй салбарууд байгуулагдаж, гэрээт албаны цэргээр нөхөн хангаж байна. Ийм учраас цэргийн эдгээр ангиудад цэргийн байлдааны бэлтгэл сургалтыг хугацаат цэргийн алба хаагчаар бүрдүүлсэн цэргийн анги, салбарын сургалтын хуучин тогтолцоогоор үргэлжлүүлэн явуулах аргагүй болох нь хэн бүхэнд ойлгомжтой байгаа биздээ.

Манай Зэвсэгт хүчний офицерын бүрэлдэхүүн бол зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний цөм юм. Офицер, ахлагчийг мэдлэг боловсрол, мэргэжил ур чадвар, албан тушаалаар хүлээсэн үүргээ гүйцэтгэж буй ажлын үр дүнг харгалзан албан тушаал дэвшүүлэн томилж байх шударга журмыг тогтоож, гуйвалтгүй мөрдлөгө болгож байх нь тэднийг хөгжүүлэх үндсэн хөшүүрэг мөн болно.

Мэргэжлийн армитай АНУ-ын цэргийн зарим зүтгэлтнүүд 2010-аад онд Армийнхаа байлдааны бэлтгэл сургалтын чанар байдалд судалгаа хийгээд армийн бүрэлдэхүүний байлдах чадавхыг сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлтэнд хүрч, цэргийн байлдааны бэлтгэл сургалтыг чанаржуулах зорилт дэвшүүлсэн байдаг. Тэд мэргэжлийн явган цэргийн байлдааны бэлтгэл сургалтыг мэргэжлийн тамирчин шиг өндөр давтамж, бэлтгэлтэй дасгал сургуулилт хийж, биеийн хүчний болоод сэтгэл зүйн бэлтгэлийг хангах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг нь анхаарал татаж байгаа юм.

Би бээр эдүгээ манай Зэвсэгт хүчний байлдааны бэлтгэл сургалтын тогтолцоо дөрвөн дэд тогтолцооноос бүрдэж байх нь зүйтэй гэж үздэг хүн.

Нэг дэх дэд тогтолцоо: Цэргийн мэргэжлийн байнгын бүрэлдэхүүнтэй байлдааны ба байлдааны жижүүлэлтийн цэргийн анги, салбарын байлдааны бэлтгэл сургалтын дэд тогтолцооны зорилго нь мэргэжлийн цэргийн алба хаагчдын мэдлэг, дадлагыг батжуулахад чиглэж байх учиртай. Энэ сургалтын технологийн горимоор сургалтын үе шат бүрийн зорилтууд нь хичээл, дадлага хоорондын уялдаа холбоог тогтоож өгнө; мөн сургалтын технологийн шат дамжлага тус бүр өөрийн өвөрмөц шинж чанарыг илэрхийлэх бөгөөд энэ нь “байлдах чадвар” хэмээх хэрэгцээнд төвлөрсөн үйл ажиллагааны горимыг баримтална; цаашлаад сургалтын технологийн шат дамжлага бүрийн үйл ажиллагааны горим нь сургалтын зарчмаар илэрхийлэгдэнэ.

Энэхүү дэд тогтолцоонд мэргэжлийн цэргийн “*хэрэгцээт*” сургалтын зарчим мөрдөгдөх учиртай. Энэхүү сургалтын зарчмыг БХЭШХ-ийн судлаачаар ажиллаж

байсан Ц.Эрдэнэгийн тусгайлсан судалгаа¹-гаар авч үзвээс:

1. Цэргийн мэргэжлийн хэрэгцээнд захируулах зарчим. Энэ зарчим нь цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөлтийн бүх шатанд сургалтын хөтөлбөр, байлдааны дүрэм, заавар, сургалтын удирдамж, зааврыг дагаж мөрдөхийн шаардана;

2. Тодорхой үүрэг, зорилгод чиглүүлэн сургах зарчим. Энэ зарчим нь захирагч нараас бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварыг байлдааны болон тусгай үүргийн төрөл, хэлбэр тус бүрд цагийн байдлын янз бүрийн нөхцөлд хөгжүүлэхийг шаардана;

3. Тэсвэр хатуужилтай, эр зоригтой болгох зарчим. Цэргийн сургалт бэлтгэлийн үе шат бүрд бие бялдар, сэтгэл зүйн өндөр тэсвэр, хатуужил шаардана. Тиймээс энэ зарчмыг сургалтын технологийн бүх шат дамжлагад баримталбал зохино;

4. Дадлага, чадварыг бүрэн эзэмшүүлэх зарчим. Энэ зарчим нь сургалтыг хөнгөн хялбараас хүнд нарийн төвөгтэй үйл ажиллагаанд ахиулан сургах, өдөр тутмын дадлага сургалтыг жижиг салбарын байлдааны жигдрэлтийг хангахад чиглүүлэх, сургалтыг хамгийн хямд төсөр арга хэлбэрээр байлдааны цагийн бодит байдалд ойртуулан зохион байгуулах, байлдааны, сургууль байлдааны болон хангалтын салбар, бүлгүүдийн сургалт дадлагыг тактикийн нэг цагийн байдал дээр явуулж, оролцогчдын мэргэжлийн чиг үүргийн харилцан уялдааг хангах аргуудыг оновчтой хэрэглэхийг нөхцөлдүүлнэ;

5. Дадлага, чадварыг батэжуулан хөгжүүлэх зарчим. Энэ зарчмыг хэрэгжүүлнэ гэдэг нь сургалтыг байлдааны болон тусгай үүргийн бүх төрөл, хэлбэр, арга ажиллагааны хүрээнд цагийн байдлыг бодитойгоор өрнүүлэх явдлаар хангагдана;

6. Захирагч дарга нэг бүрийг манлайлагч болгон бэлтгэх зарчим. Энэ зарчмыг хэрэгжүүлэх шаардлагын үүднээс бүх шатны захирагч, дарга нар цэргийн бэлтгэл сургалтыг зохион байгуулах ур чадварын шалгуур үзүүлэлтийг хангасан байвал зохино. Захирагч, дарга нарыг хөгжүүлэх явцад удирдлагын болон мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх шаардлага тавигдана;

7. Туршлага, хариуцлагын нэгдлийг хангах зарчим. Туршлага ба хариуцлагын аль нэг нь дутагдвал ур чадваргүй байна гэсэн дүгнэлт гарах болно.

Дээрх долоон зарчмыг бүхэлд нь мэргэжлийн цэргийн “хэрэгцээт сургалтын зарчим” гэж үздэг бөгөөд эдгээр нь сургалтын технологийн дотоод болон гадаад орчны үйл ажиллагааг зохицуулах, сургалтыг зохион байгуулахад үйлчилнэ.

Ийнхүү мэргэжлийн цэргийн “хэрэгцээт” сургалтыг Зэвсэгт хүчний байнгын бүрэлдэхүүнтэй цэргийн анги, салбарт шинжлэх ухаанчаар төлөвлөж, ухаалгаар зохион байгуулж, тасралтгүй явуулах аваас Зэвсэгт хүчнийг мэргэжлийн цэрэгт суурилуулан хөгжүүлэх зорилгод нийцэх болно гэж үзэж байдаг юм.

Хоёр дахь дэд тогтолоо: Монгол Улс Зэвсэгт хүчний нийт бүрэлдэхүүний тодорхой хэсгийг хугацаат цэргийн алба хаагч бүрдүүлж байх зайлшгүй шаардлага

¹ Ц.Эрдэнэ. Ерөнхий зориулалтын цэргийн салаа, салбарын байлдааны бэлтгэл сургалтыг боловсронгуй болгох асуудалд. УБ., 2009., тал 148.

байсаар байна. Цэргийн хугацаат албаны дайчдаар бүрдүүлсэн цэргийн анги, салбарын цэргийн сургалт бэлтгэлийн тогтолцоо өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой. Энэ дэд тогтолцоо нь цэргийн албанд дайчлагдан татагдан ирсэн дайчдыг сургаж бэлтгэх хэрэгцээ, шаардлага, татагдан очсон цэргийн анги, салбарын зориулалт, чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцээс хамаарч байдаг. Зэвсэгт хүчний сургалт бэлтгэлийн энэ хоёр дахь дэд тогтолцооны зорилго нь хугацаат цэргийн алба хаагчдыг алба хаах хугацаанд нь цэргийн мэргэжил заавал эзэмшүүлэхэд оршиж байгаа юм.

Хугацаат цэргийн албаны бүрэлдэхүүн бүхий цэргийн салбар, ангийн цэргийн байлдааны бэлтгэл сургалтад бидний сайн мэдэх дараах зарчмыг баримталж байна. Эдгээр зарчмуудыг нэрлэвээс:

- сургалтыг дэс дараалалтай шатлан, иж бүрэн явуулах;
- цэргийг байлдаанд шаардлагатай бүхэнд сургах;
- нэг бүрчлэн болон нийтээр нь сургах;
- мэдлэг, чадвар, дадлагыг гүн бат эзэмшүүлэх;
- цэрэг нэг бүрийн идэвх, ухамсарт тулгуурлан сургах;
- цэргийн сургалт, цэргийн хүмүүжлийн нэгдлийн хангах;
- захирагч бүр өөрт захирагдсан бүрэлдэхүүнийхээ сургалтыг биечлэн хариуцах.

Хугацаат цэргийн алба хаагчийн сургалтын эдгээр зарчимд тулгуурласан байлдааны бэлтгэл сургалт нь цэргийн алба хаагчдад мэргэжлийн мэдлэг, дадал, чадвар олгохын зэрэгцээ тэдэнд эх оронч хүмүүжил төлөвшүүлэх үйл явцын суурь үндэс болно.

Цэргийн хугацаат албаны дайчдаар бүрдүүлсэн цэргийн анги, салбарт байлдааны бэлтгэл сургалт нь *нэгд, цэргийн ерөнхий бэлтгэл, хоёрт, цэргийн мэргэжил эзэмшүүлэх сургалт, гуравт, цэргийн тасаг, салаа, салбар (анги)-ын байлдааны жигдрэлтийг хангах сургалт* гэсэн үндсэн хэсгээс бүрдэж байна. Цэргийн мэргэжил эзэмшүүлэх сургалт нь цэргийн алба хаагч нэг бүрийг тухайн цэргийн ангид байгаа цэрэгт бүртгэлтэй мэргэжил эзэмшүүлж, мэргэжлийн үнэмлэх олгох зорилготой сургалт юм. Хугацаат цэргийн алба хаагчаар бүрдүүлсэн цэргийн ангийн байлдааны бэлтгэл сургалтын үндсэн үзүүлэлт бол бэлтгэсэн цэргийн мэргэжилтний тоо байх учиртай.

Зэвсэгт хүчний байгуулалтын үндсэн зарчмын нэг бол цэргийн алба хаагч бүр цэргийн мэргэжил заавал эзэмших явдал болно. Харин хилийн ба дотоодын цэрэгт зөвхөн буудагч бэлтгэн гаргаж буйг Зэвсэгт хүчний цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага болох манай ЗХЖШ цэргийн дайчилгааны эрх ашгийн үүднээс авч үзэх шаардлагатай байгаа юм. Эдгээр цэргийн ангид хугацаат цэргийн алба хаагчид танкийн болоод артиллерын тоотын мэргэжил эзэмшүүлэх боломжгүй ч ядаж онц буудагч, пулемётчин, гранатомётчин гэх мэт мотобуудлагын цэргийн түгээмэл мэргэжил эзэмшүүлж болох л учиртай баймаар юм.

Цэргийн салбар (анги)-ын байлдааны жигдрэлтийн сургалтаар тасаг, салаа, рот (батальон)-ын байлдааны жигдрэлтийг хангах сургалт бол цэргийн салбар (анги)-

ын цэргийн алба хаагчид бүрэлдэхүүнээрээ нэгдсэн ажиллагаанд сургагдахад оршино. Тактик, тактик-жагсаалын хичээл, байлдааны буудлага, цэргийн хээрийн сургуулийн явцад байлдааны жигдрэлт хангагддаг байна.

Гурав дахь дэд тогтолцоо: Цэргийн хангалт, үйлчилгээний анги, байгууллагын цэргийн бэлтгэл сургалт. Цэргийн хангалт, үйлчилгээний анги, салбаруудыг цэргийн бие бүрэлдэхүүнээр хоёр янзаар нөхөн хангаж байна. Материал, техникийн хангалтын цэргийн анги, салбар, техникийн засварын зэрэг цэргийн байгууллагууд зөвхөн офицер, ахлагч, энгийн гэрээт алба хаагчдаар бүрдэж байгаа бол барилга-инженерийн цэргийн ангиуд, харуул-үйлчилгээний цэргийн анги, салбаруудын бие бүрэлдэхүүний дийлэнхийг хугацаат цэргийн алба хаагчдаар нөхөн хангаж байна.

Ийм учраас хангалт үйлчилгээний цэргийн анги, байгууллагын сургалтын өвөрмөц дэд тогтолцоог нөхцөлдүүлж байгаа юм. Энэ дэд тогтолцоог хоёр хэлбэрээр зохион байгуулж явуулах боломжтой гэж үзнэ. Нэг дэх нь сургуулийн жилд цэргийн алба хаагчдыг долоо хоногт 1 өдөр байлдааны бэлтгэл сургалтад харуулж байхаар, нөгөө нь сургуулийн жилийн өвлийн улиралд байлдааны бэлтгэл сургалтыг гурваас дөрвөн сараас доошгүй хугацаагаар төлөвлөн зохион байгуулж байхаар төлөвлөн зохион байгуулна. Ийм сургалтын төлөвлөлт, зохион байгуулалтыг төрлийн цэргийн командлагч, мэргэжлийн цэргийн удирдах байгууллагын дарга, штаб цэргийн хангалт үйлчилгээний анги, байгууллага тус бүрээр албан ёсоор тогтоож өгөх учиртай.

Цэргийн хангалт үйлчилгээний анги, байгууллагын цэргийн байлдааны бэлтгэл сургалт цэргийн ерөнхий бэлтгэлийн хичээлээр хязгаарлагдсаар байна. Энэ бол том дутагдал гэж үзнэ. Зүй нь тактикийн бэлтгэл, дайны байдлын үеийн зориулалт, үүрэгтэй холбоотой мэргэжлийн бэлтгэл хичээлийг мэргэшүүлэх төвшинд үзэж учиртай байгаа юм. Тактикийн бэлтгэлээр цэргийн алба хаагчийг дайны байдлын үед цэргийн бүлэглэл, нэгтгэлийн бүрэлдэхүүнд байлдааны үүрэг гүйцэтгэх арга ажиллагаанд сургах явдал болно.

Дөрөв дэх дэд тогтолцоо: Офицеруудын даргын бэлтгэл сургалт. Офицеруудын даргын бэлтгэл сургалт нь цэргийн нэгтгэл, ангийн салбар, нэгжийн офицерын бүрэлдэхүүн, штабын албан тушаалтанд операцын ба тактикийн бэлтгэлийг хангах, операц, байлдаанд цэргийг удирдах дадлага олгоход чиглэгдэж байгаа юм.

Даргалах бүрэлдэхүүний бэлтгэл сургалтын зорилго нь цэргийн анги, салбарын нийт офицеруудын байлдааны бэлтгэлийн сургалт, дадлагын нэгдлийг хангахад оршиж байна. Бид даргын бэлтгэлийг штабын бэлтгэл гэж нэрлэн зөвхөн цэргийн анги, нэгтгэлийн штабын бүрэлдэхүүний сургалт гэж ойлгон сургалт бэлтгэлийг энэ хүрээнд зохион байгуулсаар байгаа дутагдал ажиглагддаг.

Офицеруудын даргын бэлтгэл сургалт нь салбарын офицерын бэлтгэл сургалт, штабын ажилтан офицеруудын сургалт, дадлагаас бүрдэж байхыг давтан хэлье. Өөрөөр хэлбэл, офицеруудын даргын бэлтгэл сургалт нь нэгд, нийт офицеруудын албан үүргээ гүйцэтгэх чадварыг сайжруулах сургалт, хоёрт, штабын

албан тушаалтны мэргэжлийн бэлтгэлийг дээшлүүлэх сургалт, дадлагаас бүрдэх бөгөөд үндсэн зорилго нь *нэгд*, цэргийн удирдах бүрэлдэхүүнийг *“хөгжүүлэх”*; *хоёрт*, захирагч, түүний штабын бие бүрэлдэхүүнийг тайван цагийн болон дайны байдлын үеийн үйл ажиллагаанд *“жигдрүүлэх”*-д оршино.

Офицеруудын даргын бэлтгэл сургалтад *“заавал сургах-заавал сурах”* зарчим гуйвалтгүй мөрдөгдөх учиртай. Харин офицеруудын даргын бэлтгэл сургалтад *“албан сургалт”*, *“албан бус сургалт”* гэсэн хоёр хэлбэрийг ашиглана. Офицеруудын даргын бэлтгэлийн *“албан”* сургалтад офицеруудын мэргэжлийг бататгах хичээл, штабын дадлага, команд-штабын сургууль, команд-штабын хээрийн сургуулийг төлөвлөн зохион байгуулж явуулна. Эдгээр жигдрэлтийн сургалтаас гадна цэргийн нэгтгэл, анги, салбарыг байлдааны бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх дадлага, дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах сургалтыг оновчтой төлөвлөн явуулж байх учиртай.

Харин *“албан бус”* сургалтыг цэргийн нэгтгэл, ангийн захирагч, штаб өөр өөрийн онцлогийг харгалзан зохион байгуулна. Гэхдээ *“албан бус”* гээд *“та нар өөрөө өөрийгөө хөгжүүл”* гээд орхих нь үр дүн өгдөггүй болох нь практикаар тод харагддаг. Тийм учраас офицеруудын өөрийгөө хөгжүүлэх сайн арга, туршлагыг олж, цэргийн нэгтгэл, ангидаа бүтээлчээр нэвтрүүлэх нь цэргийн нэгтгэл, ангийн захирагч, штабын үүрэг байх учиртай.

Мэдээллийн эдүгээгийн эрэн үед офицерууд мэдлэг, мэдээлэл олж авах өргөн боломж байна. *“Армийн уураг тархи”* гэсэн нэрт бүтээлийг ХХ зууны эхээр туурвисан Зөвлөлтийн цэргийн нэрт зүтгэлтэн Б.М.Шапошниковын Хаант Оросын армийн цэргийн ангид алба хааж байсан үеийнхээ нэгэн дурсамждаа офицерын албан бус сургалтын нэг чухал гэж үзэж болохоор туршлагаа дурдсан байдгийг би санаж байна. Энэ ямар туршлага байв гэвэл цэргийн ангийн штаб шинэ хичээлийн жилийн эхлэхэд офицер нэг бүрд бусдадаа заах хичээлийн сэдвийг оноон өгч, сургуулийн жилийн явцад хүн бүр оноон өгсөн сэдвээр бусдадаа лекц уншиж дүгнүүлж байсан байдаг. Энэ бол санаа авах туршлага байжээ гэж үзнэ.

“Цэргийн алба хаагчдын анги, салбар дахь бэлтгэл сургалт нь цэргийн боловсрол олгох академик сургалтаас ч илүү чухал” хэмээн америкийн цэргийн нэгэн зүтгэлтэн Ази-Номхон далайн орнуудын Хуурай замын цэргийн штабын дарга нарын уулзалт дээр хэлж байсныг би санаж байна. Хэрэв тийм бол цэргийн анги, байгууллага бүрийг хүний хөгжлийн орчин болгох учиртай гэж үзэхээс өөр аргагүй байгаа юм.

Цэргийн ангийг хүний хөгжлийн орчин болгоно гэдэг бол нэгдүгээрт, алба хаагч нэг бүрт албаа хаах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх; хоёрдугаарт, цэргийн байлдааны бэлтгэл сургалт нь цэргийн алба хаагчдыг алба, ажилдаа байнга өсөн дэвшихэд үндсэн хөшүүрэг болсон бодит хэрэглээ байх; гуравдугаарт, цэргийн анги, байгууллага нь хувь хүмүүсийг хүсэл, сонирхлоороо мэдлэг, мэргэшлээ ахиулах, мэдээлэл олж авах, эрүүл мэндээ хамгаалах, бие бялдраа чийрэгжүүлэх орчин болсон байх; дөрөвдүгээрт, цэргийн албаны зохион байгуулалт нь бие хүмүүнийг албандаа сэтгэл хоёрдохгүй зүтгэх хүсэл, тэмүүллийг байнга бүрдүүлж

өгдөг байхыг хэлж байгаа хэрэг юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Юдин С. С. Солдат империи. Генерал М. И. Драгомиров. Реформатор. Учитель. Военачальник. Издательский дом, Российское военно-историческое общество, Москва, 2021.
2. Ц.Эрдэнэ. Ерөнхий зориулалтын цэргийн салаа, салбарын байлдааны бэлтгэл сургалтыг боловсронгуй болгох асуудалд. УБ., 2009.
3. Шапошников Б. М. Воспоминания: Военно-научные труды. Воениздат, Москва, 1982.
4. Ц.Дашзэвэг. Цэрэг армийн тухай. УБ., БХИС, 2007.